

# ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Дорнод аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

## АУДИТЫН КОД: ДОО-2026/02-09-СТА-НТГ

Чойбалсан хот  
2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn  
Аудитын менежер Д.Нармандах  
Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn  
Ахлах аудитор Ө.Сийлэгмаа  
Утас: 7058-4207, Цахим хаяг: siilegmaau@audit.gov.mn  
Аудитор Б.Оюунхэрлэн  
Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn  
Аудитор Б.Одхүү  
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuub@audit.gov.mn  
Аудитор С.Энхбаатар  
Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn  
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatars@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

## ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

### АГУУЛГА

|   |       |
|---|-------|
| Товчилсон үгийн тайлбар .....   | 2     |
| Хүснэгт, дүрслэлийн товъёог .....   | 2     |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй .....  | 3     |
| Аудитын шалгуур үзүүлэлт .....  | 3     |
| Аудитын багийн бүрэлдэхүүн .....  | 4     |
| БҮЛЭГ 1. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР 74.0 ХУВЬ БУЮУ 7,711.4 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВЖ БИЕЛСЭН БАЙНА. ....  | 5-9   |
| БҮЛЭГ 2. АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА 84.5 ХУВЬ БУЮУ 99,037.7 САЯ ТӨГРӨГИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БАЙНА.....           | 9-12  |
| БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ 94.6 ХУВЬТАЙ БАЙНА..... | 12-14 |
| БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН .....  | 14    |
| БҮЛЭГ 5. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ .....  | 15    |
| ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ: .....  | 16    |
| ДҮГНЭЛТ: .....  | 17    |
| ЗӨВЛӨМЖ: .....  | 17    |
| ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР .....  | 18-19 |

## ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

### Товчилсон үгийн жагсаалт

|          |  |
|----------|--|
| АДБОУС   | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт          |
| ДОА      | Дорнод аймаг   |
| ИТХ      | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                           |
| ЗДТГ     | Засаг даргын Тамгын газар                              |
| ЗДНХ     | Засаг даргын нөөц хөрөнгө                              |
| ЗГНХ     | Засгийн газрын нөөц хөрөнгө                            |
| НА       | Нийцлийн аудит   |
| ОНХС     | Орон нутгийн хөгжлийн сан                              |
| ОНХНС    | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан                      |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ҮАГ      | Үндэсний аудитын газар                                 |
| СЯ       | Сангийн яам  |
| ТӨЗ      | Төсвийн ерөнхийлөн захирагч                            |

### Дүрслэлийн товьёг

| №          | Тайлбар   | Хуудасны дугаар |
|------------|---|-----------------|
| Хүснэгт 1  | Төсвийн орлогыг Сангийн яамны хянасан төсөвтэй харьцуулсан харьцаа            | 5               |
| Хүснэгт 2  | Тодотгосон төсвийн орлогыг Сангийн яамны хянасан төсөвтэй харьцуулсан харьцаа | 5               |
| Хүснэгт 3  | Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл  | 6               |
| Хүснэгт 4  | Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл                                    | 7               |
| Хүснэгт 5  | Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл                    | 8               |
| Хүснэгт 6  | Аймгийн төсвөөс сумын төсөвт төвлөрүүлэх орлого                               | 8               |
| Хүснэгт 7  | Сангийн яамны хянасан төсвийг батлагдсан төсөвтэй харьцуулбал                 | 9               |
| Хүснэгт 8  | Сангийн яамны хянасан төсвийг батлагдсан төсөвтэй харьцуулбал                 | 9               |
| Хүснэгт 9  | Төсвийн зарлагын төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулбал                         | 9               |
| Хүснэгт 10 | Төсвийн зарлагыг анх батлагдсан төсөвтэй харьцуулсан харьцаа                  | 10              |
| Хүснэгт 11 | Зардлын төлөвлөлт, гүйцэтгэл  | 10              |
| Хүснэгт 12 | Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэл  | 12              |
| Хүснэгт 13 | Аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт                      | 13              |

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2025 оны А/179 тушаал, “Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2026 оны А/33 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн гүйцэтгэв.

### Аудитын зорилт

Дорнод аймгийн ТЕЗ-ийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалган, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- 2025 оны төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
- 2025 оны төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл
- ТЕЗ-ийн хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшин
- Төрийн аудитын байгууллагаас 2025 оны төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлтийн хэрэгжилт

### Аудитын хамарсан хүрээ

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын бэлтгэсэн Орон нутгийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн 2025 оны төсвийн гүйцэтгэл;
- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн 2025 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ;
- Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчдын 2025 онд хэрэгжүүлсэн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээ;
- Шилэн дансны болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт;
- Өмнөх оны зөвлөмжийн биелэлт.

### Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудит”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу гүйцэтгэлээ. Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан баталж, аудитын горим сорилыг хэрэгжүүллээ. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч болон бусад холбогдох хэлтэс, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, судалгаа, тоон мэдээлэл авах, түүвэрлэлт, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ, харьцуулалт хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа. Аудитын тайланд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн гүйцэтгэл, Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн

## ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнг нэгтгэсэн болно. Аудитын холбогдох мэдээлэл, ажлын баримтыг хавсаргав.

### Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Тухайн жилийн төсвийн бодлого, чиглэл, зарчим
- Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд
- Улсын Их Хурлын 2020 оны "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" 52 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам" 29 дүгээр тогтоол

### Аудитын багийн бүрэлдэхүүн

Дорнод аймгийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан баталгаажуулж, аудитын менежер Д.Нармандах үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ө.Сийлэгмаа, аудитор Б.Одхүү, Б.Оюунхэрлэн, С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

**БҮЛЭГ 1. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР 74.0 ХУВЬ БУЮУ 7,711.4 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВЖ БИЕЛСЭН БАЙНА.**

**1.1 Төсвийн орлогын төлөвлөлт**

Төсвийн ерөнхийлөн захирагч нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн жилийн төсвийн хязгаарын санал болон төсвийн төслийг боловсруулан Сангийн яаманд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасан цаглабрын дагуу хүргүүлэх үүрэгтэй.

Дорнод аймгийн 2025 оны жилийн төсвийн хязгаарыг 2024 оны 6 дугаар сарын 12-нд, 2025 оны төсвийн төслийг 2024 оны 7 дугаар сарын 24-нд Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн жилийн хүлээгдэж байгаа эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилан боловсруулсан байна.

Дорнод аймгийн 2025 оны төсвийн нийт орлогыг Сангийн яамнаас 60,410.0 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Аймгийн 2025 оны төсвийн 8,519.0 сая төгрөгөөр тооцож, Сангийн яамны хянасан дүнгээс 28,109.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Үүнд:

- ✓ Аймгийн төсвийн орлого 45,586.0 сая төгрөг,
- ✓ Сумын төсвийн орлогыг 42,933.0 сая төгрөг,

Хүснэгт 1. Төсвийн орлогыг Сангийн яамны хянасан төсөөтэй харьцуулсан харьцаа /сая төгрөг/

| Орлогын төрөл       | 2024 онд хүргүүлсэн төсвийн санал | Сангийн яамны хянасан орлого | ИТХ-аар баталсан орлого |                 |                 | Нэмэгдүүлсэн дүн |
|---------------------|-----------------------------------|------------------------------|-------------------------|-----------------|-----------------|------------------|
|                     |                                   |                              | Аймгийн дүн             | Сумын дүн       | Нийт дүн        |                  |
| Татварын орлого     | 43,604.2                          | 57,664.0                     | 16,459.0                | 41,318.4        | 57,777.4        | 113.4            |
| Татварын бус орлого | 1,645.0                           | 2,746.0                      | 29,127.0                | 1,614.6         | 30,741.6        | 27,995.7         |
| <b>ДҮН</b>          | <b>45,249.2</b>                   | <b>60,410.0</b>              | <b>45,586.0</b>         | <b>42,933.0</b> | <b>88,519.0</b> | <b>28,109.1</b>  |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны нээгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Төрийн аудитын газраас аймгийн 2025 оны төсвийн төсөлд үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 929.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал өгснийг бүрэн хэрэгжүүлж, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 1,991.5 сая төгрөгөөр баталсан байна.

Улсын төсөвт өөрчлөлт орж төсвийн тэнцлийг 10,141.0 сая төгрөг болгон улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 3,042.3 сая төгрөгөөр баталсантай холбоотойгоор аймгийн төсөвт тодотгол хийж төсвийн нийт орлогыг 60,409.0 сая төгрөгөөр баталсан байна.

Дорнод аймгийн төсвийн нийт орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 40,191.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

Хүснэгт 2. Тодотгосон төсвийн орлогыг Сангийн яамны хянасан төсөөтэй харьцуулсан харьцаа /сая төгрөг/

| Д/Д | Албан татвар, төлбөр хураамжийн нэр   | Сангийн яамны хянасан | Баталсан төсөв | Зөрүү   |
|-----|---|-----------------------|----------------|---------|
| 1   | Цалин хөлс, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөрлөх | 31,650.0              | 36,872.3       | 5,222.3 |
| 2   | Үйл ажиллагааны орлого  | 300.0                 | 1,223.2        | 923.2   |
| 3   | Хөрөнгийн орлого  | 3,470.0               | 3,430.1        | -39.9   |
| 4   | Хөрөнгө борлуулсны орлого   | 900.0                 | 9.5            | -890.5  |
| 5   | Шууд бус орлого   | 130.0                 | 708.3          | 578.3   |

**ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

|             |  |                 |                  |                 |
|-------------|--|-----------------|------------------|-----------------|
| 6           | ХХОАТ-ын буцаан олголт   | -1,800.0        | -1,763.6         | 36.4            |
| 7           | ААН-ийн орлогын албан татвар   | 10,420.0        | 10,420.0         | 0.0             |
| 8           | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар                                  | 1,062.0         | 2,022.9          | 960.9           |
| 9           | Бууны албан татвар   | 43.0            | 40.9             | -2.1            |
| 10          | Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар               | 674.0           | 722.0            | 48.0            |
| 11          | Малын тоо толгойн албан татвар                                       | -               | 1,457.3          | 1,457.3         |
| 12          | Улсын тэмдэгтийн хураамж   | 625.0           | 1,564.1          | 939.1           |
| 13          | Түгээмэл тархацтай ашигт малтмал                                     | 65.0            | 50.5             | -14.5           |
| 14          | Хог хаягдлын үйлчилгээний хураамж                                    | 1,500.0         | 1,523.9          | 23.9            |
| 15          | Газрын төлбөр  | 3,464.0         | 4,606.1          | 1,142.1         |
| 16          | Ойн нөөц ашигласны төлбөр  | 21.0            | 21.0             | 0.0             |
| 17          | Ан амьтны нөөц ашигласны төлбөр                                      | 40.0            | 113.6            | 73.6            |
| 18          | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр                                    | 5,100.0         | 5,263.3          | 163.3           |
| 19          | Хүүгийн орлого   | 15.8            | 215.8            | 200.0           |
| 20          | Торгуулийн орлого  | 1,600.0         | 2,001.6          | 401.6           |
| 21          | Төсөвт байгууллагын өөрийн орлого                                    | 24.0            | 1,355.1          | 1,331.1         |
| 22          | Газрын тосны орлого  | 56.2            | 56.2             | 0.0             |
| 23          | Бусад орлого   | 1,000.0         | 1,997.6          | 997.6           |
| 24          | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 50.0            | 50.0             | 0.0             |
| 25          | Хандив тусламж   | -               | 5,105.0          | 5,105.0         |
| 26          | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого              | -               | 22,933.70        | 22,933.7        |
| <b>Нийт</b> |  | <b>60,410.0</b> | <b>102,000.4</b> | <b>41,590.4</b> |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

**1.2 Төсвийн орлогын гүйцэтгэл**

Аймгийн 2025 оны нийт орлогын гүйцэтгэл 109,952.1 сая төгрөг болж 7,951.8 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын орлогын гүйцэтгэл 77,477.6 сая төгрөг болж 9,192.2 сая төгрөгөөр буюу 13.5 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт 3.Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Албан татвар, төлбөр хураамжийн нэр   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү   | Гүйцэтгэлийн хувь |
|-----|---|------------|-----------|---------|-------------------|
| 1   | Цалин хөлс, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөрлөх | 36,872.3   | 36,945.0  | 72.7    | 100.2             |
| 2   | Үйл ажиллагааны орлого  | 1,223.2    | 1,436.2   | 212.9   | 117.4             |
| 3   | Хөрөнгийн орлого  | 3,430.1    | 3,404.8   | -25.3   | 99.3              |
| 4   | Хөрөнгө борлуулсны орлого   | 9.5        | 94.8      | 85.2    | 994.7             |
| 5   | Шууд бус орлого   | 708.3      | 813.7     | 105.3   | 114.9             |
| 6   | ХХОАТ-ын буцаан олголт  | -1,763.6   | -1,763.5  | 0.1     | 100.0             |
| 7   | ААН-ийн орлогын албан татвар  | 10,420.0   | 18,131.40 | 7,711.4 | 174.0             |
| 8   | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар   | 2,022.9    | 2,340.5   | 317.6   | 115.7             |
| 9   | Бууны албан татвар  | 40.9       | 39.4      | -1.5    | 96.4              |
| 10  | Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар                                | 722.0      | 768.6     | 46.6    | 106.5             |
| 11  | Малын тоо толгойн албан татвар  | 1,457.3    | 1,757.0   | 299.7   | 120.6             |

## ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

|             |                                   |                 |                 |                |              |
|-------------|-----------------------------------|-----------------|-----------------|----------------|--------------|
| 12          | Улсын тэмдэгтийн хураамж          | 1,564.1         | 3,171.0         | 1,607.0        | 202.7        |
| 13          | Түгээмэл тархацтай ашигт малтмал  | 50.5            | 26.5            | -24.0          | 52.5         |
| 14          | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 1,523.9         | 1,034.9         | -489.0         | 67.9         |
| 15          | Газрын төлбөр                     | 4,606.1         | 4,255.8         | -350.3         | 92.4         |
| 16          | Ойн нөөц ашигласны төлбөр         | 21.0            | 16.2            | -4.8           | 77.3         |
| 17          | Ан амьтны нөөц ашигласны төлбөр   | 113.6           | 123.6           | 10.0           | 108.8        |
| 18          | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 5,263.3         | 4,881.7         | -381.6         | 92.8         |
| <b>Нийт</b> |                                   | <b>68,285.4</b> | <b>77,477.6</b> | <b>9,192.2</b> | <b>113.5</b> |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Татварын орлого давж биелэхэд аж ахуй нэгжийн орлогын албан татвар 7,711.4 сая төгрөгөөр давж биелсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Энэ нь олон жил алдагдалтай ажиллаж байсан уул уурхайн компани ашигтай ажиллаж эхэлсэнтэй холбоотой байна.

Аймгийн 2025 оны татварын орлогын биелэлтийг нэр төрлөөр авч үзвэл 1,477.3 сая төгрөгөөр 6 нэр төрлийн татвар тасарсан байна.

Үүнд:

- ✓ Түгээмэл тархацтай ашигт малтмал 24.0 сая төгрөгөөр,
- ✓ Хог хаягдлын үйлчилгээний хураамж 489.0 сая төгрөгөөр,
- ✓ Газрын төлбөр 576.5 сая төгрөгөөр,
- ✓ Ус рашаан ашигласны төлбөр 381.6 төгрөгөөр,
- ✓ Ойн нөөц ашигласны төлбөр 4.8 сая төгрөгөөр,
- ✓ Галт зэвсгийн албан татвар 1.5 сая төгрөгөөр,

Татварын бус орлогын гүйцэтгэл 32,474.5 сая төгрөг буюу 96.3 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

| д/д        | Албан татвар, төлбөр хураамжийн нэр                                  | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Зөрүү           | Гүйцэтгэлийн хувь |
|------------|--|-----------------|-----------------|-----------------|-------------------|
| 1          | Хүүгийн орлого   | 215.8           | -               | -215.8          | -                 |
| 2          | Торгуулийн орлого  | 2,001.6         | 2,945.2         | 943.6           | 147.1             |
| 3          | Төсөвт байгууллагын өөрийн орлого                                    | 1,355.1         | 1,129.3         | -225.8          | 83.3              |
| 4          | Газрын тосны орлого  | 56.2            | -               | -56.2           | -                 |
| 5          | Бусад орлого   | 1,997.6         | 2,020.6         | 22.9            | 101.1             |
| 6          | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 50.0            | 55.8            | 5.8             | 111.5             |
| 7          | Хандив тусламж   | 5,105.0         | 3,990.0         | -1,115.0        | 78.2              |
| 8          | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого              | 22,933.70       | 22,333.7        | -600.0          | 97.4              |
| <b>Дүн</b> |  | <b>33,714.9</b> | <b>32,474.5</b> | <b>-1,240.4</b> | <b>96.3</b>       |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Татварын бус орлого тасрахад хүүгийн орлого болон хандив тусламжийн орлого голлон нөлөөлжээ.

- ✓ Хүүгийн орлого 215.8 сая төгрөг нь Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуй хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл” МОН1907-ийн хүрээнд авсан зээлийн хүүгийн төлбөрийг “Дорнод НАА” ОНӨҮГ-аас төвлөрүүлж, Засгийн газарт төлөхөөр төлөвлөсөн орлого байна. “Дорнод НАА” ОНӨҮГ нь тайлант онд алдагдалтай ажилласнаас үүдэн тухайн хүүгийн төлбөрийг төлөөгүй байна.
- ✓ Хандив тусламжийн орлого 5,105.0 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн нь 78.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчтай гэрээ байгуулсан газрын тос, уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах байгууллагууд 1,675.0 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

## ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

- ✓ *Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутагт шилжүүлэх орлогыг Сангийн яамнаас 600.0 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2-д “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ” 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 16,761.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс 14,859.5 сая төгрөгийг шилжүүлж 1,902.0 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн байна.

*Хүснэгт 5. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл /сая төгрөгөөр/*

| №           | Сумын нэр        | Анх баталсан    | Тодотгосон      |                 | Зөрүү          | Гүйцэтгэлийн хувь |
|-------------|------------------|-----------------|-----------------|-----------------|----------------|-------------------|
|             |                  |                 | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       |                |                   |
| 1           | Баяндун сум      | 955.2           | 757.5           | 718.2           | 39.2           | 94.8              |
| 2           | Баянтүмэн сум    | 1,468.2         | 1,181.5         | 982.0           | 199.6          | 83.1              |
| 3           | Баян-Уул сум     | 733.3           | 562.5           | 548.4           | 14.1           | 97.5              |
| 4           | Булган сум       | 605.4           | 473.6           | 452.0           | 21.6           | 95.4              |
| 5           | Гурванзагал сум  | 462.6           | 365.2           | 356.0           | 9.1            | 97.5              |
| 6           | Дашбалбар сум    | 1,564.8         | 1,353.5         | 832.2           | 521.3          | 61.5              |
| 7           | Матад сум        | 5,235.0         | 4,060.0         | 3,734.2         | 325.7          | 92.0              |
| 8           | Сэргэлэн сум     | 462.1           | 370.1           | 289.9           | 80.2           | 78.3              |
| 9           | Халхгол сум      | 2,484.9         | 1,873.7         | 1,622.1         | 251.6          | 86.6              |
| 10          | Хөлөнбуйр сум    | 371.3           | 290.3           | 283.1           | 7.3            | 97.5              |
| 11          | Хэрлэн сум       | 3,740.5         | 2,904.6         | 2,823.2         | 81.4           | 97.2              |
| 12          | Цагаан-Овоо сум  | 1,208.0         | 1,011.1         | 722.6           | 288.5          | 71.5              |
| 13          | Чойбалсан сум    | 1,464.7         | 1,174.9         | 1,122.1         | 52.8           | 95.5              |
| 14          | Чулуунхороот сум | 502.3           | 383.1           | 373.5           | 9.6            | 97.5              |
| <b>Нийт</b> |                  | <b>21,258.3</b> | <b>16,761.5</b> | <b>14,859.5</b> | <b>1,902.0</b> | <b>88.7</b>       |

*Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.*

Сумдын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг анх дараах 5 сумаас нийт 21,350.1 сая төгрөгөөр, тодотголоор орлогыг 1,903.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 23,253.1 сая төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт 6. Аймгийн төсвөөс сумын төсөвт төвлөрүүлэх орлого /сая төгрөгөөр/*

| №               | Сумын нэр       | Төвлөрүүлэх /Анх баталсан/ | Тодотголоор өөрчилсөн | Тодотголоор баталсан | Төвлөрүүлсэн орлого | Зөрүү          |
|-----------------|-----------------|----------------------------|-----------------------|----------------------|---------------------|----------------|
| 1               | Дашбалбар сум   | 2,678.6                    | (275.9)               | 2,402.7              | 2,402.7             | -              |
| 2               | Матад сум       | 936.5                      | (546.2)               | 390.3                | 390.3               | -              |
| 3               | Халхгол сум     | 355.2                      | (257.0)               | 98.2                 | 98.2                | -              |
| 4               | Хэрлэн сум      | 17,084.9                   | 3,277.1               | 20,362.0             | 19,462.0            | (900.0)        |
| 5               | Цагаан-Овоо сум | 294.9                      | (294.9)               | -                    | -                   | -              |
| <b>Нийт дүн</b> |                 | <b>21,350.1</b>            | <b>1,903.0</b>        | <b>23,253.1</b>      | <b>22,353.1</b>     | <b>(900.0)</b> |

*Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан*

Аймагт төвлөрүүлэх орлогыг дээрх 4 сумаас 1,374.1 сая төгрөгөөр бууруулан, 1 сумаас 3,277.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсон нь Төсвийн тухай хуулийн 56.2.1-т “доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас бага болон тэнцүү тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн 70 хувийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ”, 56.2.2-т “доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь

## ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

зарлагаас их тохиолдолд суурь зарлагатай тэнцэх хэсгийн 70 хувийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ” гэж заасантай нийцэж байна.

Хэрлэн сум аймгийн төсөвт 20,362.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 900.0 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2-д “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ” 41.2.1-д “хуулийн дагуу улс, **орон нутгийн төсөвт оруулах** болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны **орлогыг бүрэн төвлөрүүлэх**” гэж заасантай нийцэхгүй байна.

### БҮЛЭГ 2. АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА 84.5 ХУВЬ БУЮУ 99,037.7 САЯ ТӨГРӨГИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БАЙНА.

#### 2.1 Төсвийн зарлагын төлөвлөлт

Дорнод аймгийн 2025 оны төсвийн нийт зарлагыг Сангийн яам 59,526.7 сая төгрөгөөр хянасныг 14,667.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 74,194.6 сая төгрөгөөр баталсан байна.

Үүнд:

- ✓ Аймгийн төсвийн зарлагыг 45,586.0 сая төгрөг,
- ✓ Сумын төсвийн зарлагыг 28,608.6 сая төгрөг,

Хүснэгт 7. Сангийн яамны хянасан төсвийг батлагдсан төсөвтэй харьцуулбал

/сая төгрөгөөр/

| Зарлагын төрөл   | 2024 онд хүргүүлсэн төсвийн санал | Сангийн яамны хянасан зардал | ИТХ-аар баталсан зардал |                 |                  | Нэмэгдүүлсэн дүн |
|------------------|-----------------------------------|------------------------------|-------------------------|-----------------|------------------|------------------|
|                  |                                   |                              | Аймгийн дүн             | Сумын дүн       | Нийт дүн         |                  |
| Урсгал зардал    | 50,889.1                          | 59,526.8                     | 30,245.2                | 28,608.6        | 58,853.8         | (673.0)          |
| Хөрөнгийн зардал | 30,732.5                          | 30,428.3                     | 24,510.8                | 21,258.3        | 45,769.1         | 15,340.8         |
| <b>ДҮН</b>       | <b>81,621.6</b>                   | <b>89,955.1</b>              | <b>54,756.0</b>         | <b>49,866.9</b> | <b>104,622.9</b> | <b>14,667.8</b>  |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 08-ны 05/01 дугаар тогтоолоор аймгийн төсөвт тодотгол хийн төсвийн нийт зарлагыг 117,175.1 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 8. Сангийн яамны хянасан төсвийг батлагдсан төсөвтэй харьцуулбал

/сая төгрөгөөр/

| Зарлагын төрөл   | 2024 онд хүргүүлсэн төсвийн санал | Сангийн яамны хянасан зардал | ИТХ-аар баталсан зардал |                 |                 | Нэмэгдүүлсэн дүн |
|------------------|-----------------------------------|------------------------------|-------------------------|-----------------|-----------------|------------------|
|                  |                                   |                              | Аймгийн дүн             | Сумын дүн       | Нийт дүн        |                  |
| Урсгал зардал    | 50,889.1                          | 50,269.9                     | 25,980.4                | 26,723.5        | 52,703.9        | 2,434.0          |
| Хөрөнгийн зардал | 30,732.5                          | 22,933.7                     | 24,002.4                | 16,761.5        | 40,763.9        | 17,830.2         |
| <b>ДҮН</b>       | <b>81,621.6</b>                   | <b>73,203.6</b>              | <b>49,982.8</b>         | <b>43,485.0</b> | <b>93,467.8</b> | <b>20,264.2</b>  |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нийт зарлага өмнөх оноос 10,418.3 сая төгрөг буюу 9.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 9. Төсвийн зарлагын төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулбал:

/сая төгрөгөөр/

| Зардлын ангилал     | 2024 оны төлөвлөгөө | 2025 оны төлөвлөгөө | Зөрүү           |
|---------------------|---------------------|---------------------|-----------------|
| Урсгал зардал       | 53,559.3            | 64,376.2            | 10,816.9        |
| Хөрөнгийн зардал    | 51,644.4            | 50,454.7            | -1,189.7        |
| Эргэж төлөгдөх зээл | 1,553.1             | 2,344.2             | 791.1           |
| <b>Дүн</b>          | <b>106,756.8</b>    | <b>117,175.1</b>    | <b>10,418.3</b> |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

## ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аймгийн 2025 оны төсвийн зарлагыг 76,848.8 сая төгрөгөөр баталж, тодотголоор 5,333.5 сая төгрөгөөр бууруулж 71,515.3 сая төгрөг болгож өөрчлөн баталсан байна.

Хүснэгт 10. Төсвийн зарлагыг анх батлагдсан төсөвтэй харьцуулсан харьцаа /сая төгрөг/

| Үзүүлэлт                 | 2025 оны<br>Батлагдсан төсөв<br>/2024.12.20/ | 2025 оны<br>Тодотгосон төсөв<br>/2025.08.08/ |
|--------------------------|--|--|
| Урсгал зардал            | 31,079.7                                     | 30,751.5                                     |
| Хөрөнгийн зардал         | 45,769.1                                     | 40,763.9                                     |
| <b>Нийт зарлагын дүн</b> | <b>76,848.8</b>                              | <b>71,515.3</b>                              |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын орон тоог Сангийн яамны хянасан дүнгээс хэтрүүлэн төлөвлөсөн байна. Үүнд:

- ✓ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын орон тоог гүйцэтгэлээр 4 орон тоогоор хэтрүүлсэн нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд хурал өөрөө тогтооно”, Засгийн газрын 2021 оны 376 дугаар “Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны бүтэц, аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалттай тус тус нийцэхгүй байна.
- ✓ Аймгийн Засаг даргын Тамгын газрын орон тоог 17-гоор, Сумдын Засаг даргын Тамгын газрын орон тоог 24-өөр, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны орон тоог 4-өөр тус тус хэтрүүлсэн байна. Энэ Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна”, 31.1.3-д “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх” гэж заасантай нийцэхгүй байна.

### 2.2. Төсвийн зарлагын гүйцэтгэл

Аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу тайлагнан ирүүлсэн.

Аймгийн төсвийн нийт зарлага 84.5 хувь буюу 99,037.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Нийт зардлын 58.9 хувийг урсгал зардал, 39.8 хувийг хөрөнгийн зардал, 1.3 хувийг эргэн төлөгдөх зээл эзэлж байна.

Хүснэгт 11. Зардлын төлөвлөлт, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

| Код       | Үзүүлэлт                                   | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл       | Зөрүү           |
|-----------|--|------------------|-----------------|-----------------|
| <b>II</b> | <b>НИЙТ ЗАРДАЛ БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>    | <b>117,175.1</b> | <b>99,037.7</b> | <b>18,137.4</b> |
| 21        | Урсгал зардал                              | 64,376.2         | 58,298.5        | 6,077.7         |
| 210       | Бараа, ажил үйлчилгээний зардал            | 59,251.5         | 53,390.6        | 5,860.9         |
| 211       | Хүү  | 215.8            | 215.8           | -               |
| 213       | Урсгал шилжүүлэг                           | 4,908.9          | 4,692.1         | 216.8           |
| 22        | Хөрөнгийн зардал                           | 50,454.7         | 39,475.8        | 10,978.9        |
| 223       | Бусад хөрөнгө                              | 50,454.7         | 39,475.8        | 10,978.9        |
| 23        | Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | 2,344.2          | 1,263.4         | 1,080.8         |
| 230       | Эргэж төлөгдөх зээл                        | 2,344.2          | 1,263.4         | 1,080.8         |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр Дорнод аймгийн улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 3,042.3 сая төгрөгөөр баталсныг бүрэн шилжүүлсэн байна.

## ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Бараа, ажил үйлчилгээний зардлыг 5,860.9 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 10,978.9 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь оны эцэст Сангийн яамнаас төрийн сангийн гүйлгээнд хязгаарлалт тавьсантай холбоотой байна.

Эргэн төлөгдөх зээлийн төлбөрийн гүйцэтгэл 1,080.8 сая төгрөгөөр дутуу байгаа нь 6 сумын хоршоо хөгжүүлэх сан тайлант хугацаанд аж ахуйн нэгж байгууллага, иргэнд зээл олгоогүйтэй холбоотой байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс малын халдварт өвчин, гамшгаас сэргийлэх үйл ажиллагаанд 367.3 сая төгрөг, сумдад архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг зохион байгуулахад шаардагдах зардалд 7.6 сая төгрөг, хүн ам орон сууцны завсрын тооллого зохион байгуулахад 2.4 сая төгрөг, гадаад хамтын ажиллагааны хүрээнд 28.1 сая төгрөг, төрийн байгууллага, хувь хүнд нэг удаагийн шинжтэй буцалтгүй тусламж дэмжлэгт 81.3 сая төгрөг, нийт 486.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс Австрали Улсын Брисбен хотноо зохион байгуулагдах Ази, Номхон далайн бүс нутгийн татварын байгууллагуудын 54 дэх удаагийн хуралдаан "СГАТАР-54" уулзалтад оролцоход зориулж 5.1 сая төгрөгийн зардлыг төрийн албан хаагчид олгосон байна.

### **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаагүй, үр дүн гүйцэтгэлийг тайлагнаагүйгээс ТЕЗ-ийн хамрах хүрээний байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 112.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 15.0 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 97.0 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлсэн.

### **Худалдан авах ажиллагааны хэрэгжилт.**

Дорнод аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/04 дүгээр тогтоолоор тайлант онд хэрэгжүүлэх 19,115.5 сая төгрөгийн 80 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад байршуулсан байна.

Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд 18,695.0 сая төгрөгийн 79 орон нутгийн төсвөөс санхүүжих төсөл, арга хэмжээ, улсын төсвөөс эрх шилжиж ирсэн 420.5 сая төгрөгийн 1 ажлыг зохион байгуулахаар тусгасан байна.

Тайлант хугацаанд 2,659.6 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Үүнд:

- ✓ Гүйцэтгэлээр 440.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний ажлыг хэрэгжүүлээгүй,
- ✓ 1,298.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээний ажлыг зарласан боловч оролцогч үнийн санал ирүүлээгүй,
- ✓ 921.6 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулсан боловч гүйцэтгэгч гэрээ байгуулаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-ийн дагуу гэрээ байгуулаагүй байна.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилттэй холбоотой Дорнод аймгийн Засаг даргын хамрах хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 674.7 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

1. Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ нь худалдан авалтын төлөвлөгөөнд харьцуулалтын аргаар шалгаруулах 40,109.1 мянган төгрөгийн урсгал зардлыг үнэлгээний хорооны тэмдэглэлд дахин тендер зарлахаар шийдвэрлэсэн боловч гүйцэтгэлээр 124.240.2 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн,
2. Халхгол нэгдэл ОНӨААТҮГ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй 419,762.7 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн,
3. Хэрлэн тохижилт ОНӨААТҮГ нь ХАА-г зохион байгуулалгүй 84.2 сая төгрөгийн худалдан авалт хийсэн,

## ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

4. Дорнод нийтийн аж ахуй ОНӨААТҮГ нь Тайлант хугацаанд Лэмдгэлиш ХХК-иас 32.1 сая төгрөгийн ажлын хувцас худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаараас доош үнээр жижиглэн 1 өдөр /2025.03.31/, 1 компанитай 2 гэрээ /№11,12 дугаартай/ байгуулан худалдан авалтыг хийсэн байна.

5. Хэрлэн сумын ИТХ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгүй 14,359.1 сая төгрөгийн 3 компьютерыг шууд худалдан авалтаар авсан байна.

### Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэл.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 2,262.9 сая төгрөгийн орлого авч, 2,244.2 сая төгрөгийг зарцуулан, 18.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- ✓ Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 190.6 сая төгрөг,
- ✓ Нийгмийн даатгалын шимтгэлд 5.2 сая төгрөг,
- ✓ Хангамж, бараа материалын зардалд 50.9 сая төгрөг,
- ✓ Норматив зардалд 1.5 сая төгрөг,
- ✓ Эд хогшил, урсгал засварын зардалд 12.9 сая төгрөг,
- ✓ Томилолтын зардалд 4.7 сая төгрөг,
- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 865.6 сая төгрөг,
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 1,107.9 сая төгрөг,
- ✓ Нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 4.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 12. Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэл

| Код       | Үзүүлэлт  | /сая төгрөгөөр/<br>Тайлант оны<br>гүйцэтгэл |
|-----------|---|---|
| <b>II</b> | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>  | <b>2,244.2</b>                              |
| 21        | Урсгал зардал   | 2,244.2                                     |
| 210       | Бараа, ажил үйлчилгээний зардал   | 2,239.3                                     |
| 213       | Урсгал шилжүүлэг  | 4.9   |
| <b>I</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | <b>2,262.9</b>                              |
| 131       | Нэмэлт санхүүжилтийн орлого   | 2,262.9                                     |
| 1311      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж   | 111.5                                       |
| 1312      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 772.4                                       |
| 1313      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 703.5                                       |
| 1314      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                | 675.4                                       |

Эх сурвалж: Дорнод аймгийн 2025 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.

## БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ 94.6 ХУВЬТАЙ БАЙНА.

### 3.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ.

ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 94.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- **Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ:** Хөрөнгө оруулалтын 3,894.4 сая төгрөгийн 12 арга хэмжээ төлөвлөж 3,806.6 сая төгрөгөөр 10 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 87.8 сая төгрөгийн 2 арга хэмжээ хэрэгжээгүй, 190.9 сая төгрөгийн ажил 2 ажил дутуу хэрэгжсэн байна. Энэ нь тендерт гүйцэтгэгч шалгарсан ч гэрээ байгуулаагүй, тендерт шалгарсан компани нь ажлаа бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тайлант оны төсөл, арга хэмжээний хэрэгжилт 83.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### Аудитын илрүүлэлт:

1. Дорнод аймагт 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламжийн геодези, геологийн судалгаа, ТЭЗҮ, зураг төсвийн 58.8 сая төгрөгийн ажил хийгдээгүй байна.
- 2.Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн халаалтын систем, гадна, дотор, инженерийн шугам сүлжээний их засвар, шинэчлэлт /29.1 сая төгрөг/ хэрэгжээгүй
3. Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих ажил дутуу хийгдсэн. /140.9 сая төгрөг/
4. Нутгийн удирдлагын байрны тохижилт, тоног төхөөрөмж дутуу хэрэгжсэн /50.0 сая төгрөг /

## ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

- **Хөрөнгө оруулалтын бус төсөл арга хэмжээ:** Хөрөнгө оруулалтын бус 5,002.0 сая төгрөгийн 58 арга хэмжээ төлөвлөснөөс 500.0 сая төгрөгийн 1 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Энэ ажил нь Зүүн бүсийн зөвлөгөөн зохион байгуулах байсан боловч Төсвийн хэмнэлттэй холбоотой Засгийн газрын шийдвэр гарч зохион байгуулаагүй байна. Тайлант оны төсөл, арга хэмжээний хэрэгжилт 98.3 хувийн гүйцэтгэлтэй байна.
- **Аймгийн орон нутгийн хөгжлийн сан:** Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 12,446.2 сая төгрөгийн 80 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Батлагдсан төсөл, арга хэмжээний 1,087.7 сая төгрөгийн 4 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Төндөрт шалгарсан компани нь гүйцэтгэлээ гаргаж өгөөгүй, ажлаа бүрэн хийгээгүй байна. Тайлант оны төсөл, арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувийн гүйцэтгэлтэй байна.
 

**Аудитын илрүүлэлт:**  
 1. Дорнод аймагт 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ТЭЗҮ, зураг төсөв /119.4 сая төгрөг/  
 2. Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилга барих (Баянтүмэн сум) 217.9 сая төгрөг  
 3. Нийтийн эзэмшлийн зам талбайг камержуулах (Хэрлэн сум) 874.8 сая төгрөг  
 4. Дорнод аймагт 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын зураг төсвийн зардал / 62.5 сая төгрөг/
- **Автозамын сан:** Авто замын сангийн хөрөнгөөр 1,248.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Батлагдсан төсөл, арга хэмжээний ажил бүрэн хэрэгжсэн байна. Тайлант оны төсөл, арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.
- **Байгаль орчныг хамгаалах зардал:** Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар 1,075.9 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Батлагдсан төсөл, арга хэмжээний 23.0 сая төгрөгийн 1 ажил хэрэгжээгүй байна. Тайлант оны төсөл, арга хэмжээний хэрэгжилт 96.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7 -д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэж заасантай нийцэхгүй байна.

### 3.2 Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт.

Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны “Аргачлал батлах тухай” А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу “Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулан Аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 03/02 дугаар тогтоолоор баталсан ба хөгжлийн төлөвлөгөөнд салбарын 13 үр дүн, ТЭЗ-ийн 25 үр дүнгийн хүрээнд 134 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 90 хувиар үнэлснийг ИТХ-ын хурлын тогтоолоор “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

Хүснэгт 13. Аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт

| Хэрэгжилт гарах нийт арга хэмжээний тоо: |  | 134        |
|--|--|------------|
| 1  | "Үр дүнтэй" (хэрэгжилтийн явц зорилтот түвшний 85 хувиас дээш)           | 115        |
| 2  | "Үр дүн хүлээгдэж байгаа" (хэрэгжилтийн явц зорилтот түвшний 60-84 хувь) | 5          |
| 3  | "Үр дүн хангалтгүй" (хэрэгжилтийн явц зорилтот түвшний 30-59 хувь)       | 4          |
| 4  | "Үр дүн гараагүй" (хэрэгжилтийн явц зорилтот түвшний 0-29 хувь дээш)     | 10         |
| 5  | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй"                                   | -          |
| <b>Хэрэгжилтийн дундаж хувь:</b>         |  | <b>90%</b> |

Эх үүсвэр: Аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө

## ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Дорнод аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэлийг 88.0 хувиар, Дорнод аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 92.1 хувиар тус тус үнэлснийг аймгийн ИТХ-д хүргүүлсэн боловч хурлаар хэлэлцэж үнэлээгүй байна.

Энэ нь МУЗЗНДНТУ-ын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Дорнод аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, мөн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс болон аймгийн ИТХ бодитой үнэлгээ өгсөн эсэхэд эргэлзээтэй байна. Тухайлбал:

- ✓ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2-т газрын төлбөр 576.5 сая төгрөгөөр тасарсан гүйцэтгэлийг 100 хувийн биелэлттэй гэж үнэлсэн;
- ✓ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.2.2-т шинээр тариалангийн талбай нэмэгдээгүй боловч атар болон атаршсан газрыг эргэлтэд оруулсан гэж үзэн газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн хэмээн 100 хувиар үнэлсэн;
- ✓ Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2.1.1.4-т түргэн тусламжийн автомашиныг 2-оор нэмэгдүүлэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1-ийг нэмэгдүүлснийг 100 хувийн биелэлттэй гэж үнэлсэн;
- ✓ Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний 1.1.1.1-д Баянтүмэн сумын ЕБС-ийн спорт заалны санхүүжилтийг 1,373.4 сая төгрөгөөр төлөвлөсөн ч 686.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байхад 100 хувиар үнэлсэн;
- ✓ Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний 1.1.1.2-т СӨБ болон ЕБС-ийн барилгын засварын 18 ажлыг төлөвлөснөөс 14-ийг гүйцэтгээд 100 хувиар үнэлүүлсэн байна.

### СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Ерөнхий чиглэлийн судалгаанд орон нутгийн 35 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот 24 байгууллагыг хамруулан, 11 байгууллагатай холбоотой 56.7 сая төгрөгийн зөрчил илэрсэнд холбогдох арга хэмжээг авч ажилласан.

1. Унаа, хооны зардлын судалгаагаар аймгийн хэмжээнд 501.7 сая төгрөгийг төлөвлөж 414.1 сая төгрөгийг олгосон байна. Нийт 59 байгууллагаас 13 байгууллага нь 1.0-15.0 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна. Хоолны 1 өдөрт олгосон хөнгөлөлт Чойбалсан сумын ИТХ- 4.0 мянган төгрөг, Баянтүмэн ИТХ-5.0 мянган төгрөг, Чойбалсан ЗДТГ-5.0 мянган төгрөг, Чулуунхороот ЗДТГ-6.0 мянган төгрөг, Чулуунхороот ИТХ-6.0 мянган төгрөг, Байгаль орчны газар-15.0 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-15.0 мянган төгрөг, Худалдан авах ажиллагааны газар-15.0 мянган төгрөг, Санхүүгийн хяналт аудитын газар-15.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-5.0 төгрөг, Булган ЗДТГ-1.0 мянган төгрөг, Баянтүмэн ЗДТГ-5.0 мянган төгрөг, орон нутгийн өмчийн газар-5.0 мянган төгрөг байгаа нь харилцан адилгүй олгосон байна.
2. Гадаад томилолт, арга хэмжээний зардлын судалгаагаар 11.0 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэн. Үүнд: Хэрлэн тохижилт ОНӨААТҮГ нь 2.0 сая төгрөгийн гадаад томилолтын зардлын баримтын бүрдэл дутууд төлбөрийн акт тогтоож, аймгийн ЗДТГ-аас Австрали улсад зохион байгуулсан уулзалтад оролцоход зориулж 5.1 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосонд албан шаардлага, Хэрлэн сумын ИТХ нь бараа үйлчилгээний бусад зардлаас 3.9 сая төгрөгийг гадаад томилолтод зарцуулсанд албан шаардлага хүргүүлсэн байна.
3. Төрд учирсан хохирол барагдуулах зардлын судалгаагаар Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт олгосон 45.7 сая төгрөгийн авлагын 21.7 сая төгрөг буюу 47.5 хувь нь 2018 онд, 24.0 сая төгрөг буюу 52.5 хувь 2022 онд үүссэн байна.

## ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН


4. Программ хангамжийн бүртгэлтэй холбоотой судалгаагаар алдаа зөрчил илрээгүй.
5. Сургалт семинар, хурал зөвлөгөөний зардлын судалгаагаар алдаа зөрчил илрээгүй.
6. ТБОНӨ хуулийн этгээдийн судалгаагаар Аймгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах чиглэлээр сум бүхэнд 2-3 орон тоотой байгаль орчны тасаг, 3 сум дундын ойн анги, 3 суманд Сав газрын захиргаа ажиллаж байгаа боловч "Байгаль хамгаалалтын захиргаа" ОНӨААТҮГ, болон "Буйр нуурын экосистемийг хамгаалах аялал жуулчлал хөгжүүлэх төв" ОНӨААТҮГ-ыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн ажиллуулж байгаа нь УИХ-ын 2024 оны 54 дүгээр тогтоолоор баталсан "бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.
7. Байгууллагын орон тооны цомхотголын судалгаагаар Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан бодлого чиглэлийн хэрэгжилттэй холбогдуулан ТЕЗ-ийн хамрах хүрээний 59 байгууллагаас бүтэц орон тоо бууруулаагүйд 1 албан шаардлага, 15 зөвлөмж өгсөн. Аймгийн ЗДТГ нь 3 орон тоогоор илүү ажилласан бол сумын ЗДТГ-ууд батлагдсан орон тооноос 1-3 орон тоо дутуу ажилласан байна.
8. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээллийн судалгаагаар алдаа зөрчил илрээгүй байна.

### **ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ 88.7 ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ БАЙНА.**

Төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 88.7 хувийн хэрэгжилттэй байна. Үүнд:

1. Төрийн аудитын байгууллагаар хянагдаагүй төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх зөвлөмжийн биелэлт – 32.1 хувийн хэрэгжилттэй.
2. Хөдөө аж ахуйн сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх "Арван мянган хүлэмж" төслийн хэрэгжилтэд өгсөн албан шаардлагын биелэлт - 100 хувийн хэрэгжилттэй.
3. ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд санал аваагүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн – 100 хувийн хэрэгжилттэй.
4. Сумдын төсвийн орлогын төлөвлөлтөд арга зүйн зөвлөгөө өгч, хяналтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж -100 хувийн хэрэгжилттэй.
5. Дорнод аймгийн 2025 оны төсвийн төсөлд зарлага бууруулах саналын 719.5 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг бууруулалгүй баталж, төсвийн тодотголоор бууруулж хэрэгжүүлж ажилласан байна -100 хувийн хэрэгжилттэй.
6. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд өгсөн зөвлөмж – 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

**ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ:**

|   |   |
|---|---|
| <br>МОНГОЛ УЛС<br>ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА<br>Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг<br>Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000<br>Утас: 7058-4202, факс: 7058-4584<br>Цахим шуудан: azdtg@dornod.gov.mn<br>Цахим хуудас: Dornod.gov.mn  | <p>Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН<br/>АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,<br/>ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ<br/>ТАНАА</p> |
| <p><i>2026.04.25 № 01/1050</i></p> <p>танай _____ -ны № _____ -т</p>  |   |
| <p>Г Тайлангийн төсөлд санал хүргүүлэх Г<br/>тухай</p>  |   |
| <p>Аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.</p> <p>Тайлангийн төсөлд дараах өөрчлөлтүүдийг тусгуулах саналтай байна. Үүнд:</p> <p>-Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн биелэлт гэсэн хэсэгт аудитын байгууллагаар хянагдаагүй төсөл арга хэмжээ төсөвт тусгахгүй байх зөвлөмжийн биелэлт бүрэн хэрэгжээгүй талаар тусгажээ. Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхийн өмнө аудитын дүгнэлт өгөгддөг бөгөөд Хурлын Төлөөлөгчид хэлэлцэх явцдаа өөрчлөлт оруулах санал өгөх нь тэдний бүрэн эрхийн асуудал юм. Уг саналаас хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн төсөл арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төсөлд нэмж тусгах, хурал түүнийг хэлэлцэн батлах эрх нээлттэй байдаг бөгөөд аудитын дүгнэлтээс хойш төсөл арга хэмжээ нэмэхийг хориглосон зохицуулалт байхгүй тул зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүй юм. Мөн 2024 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар ийм зөвлөмж өгөгдөөгүй байгааг хянаж үзэж тайланд тусгах</p> <p>-Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамрах хүрээний асуудал, зөрчлийн дүн болон өгч байгаа зөвлөмж нь санхүүгийн тайлангийн аудитын хамрах хүрээ, өгсөн зөвлөмжтэй давхцаж байгааг хянан үзэж тайланд тусгах</p> <p>Дээрх агуулгаас бусад аудитын дүн дүгнэлтэд тусгасан асуудлын тухайд сайжруулах, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлд анхааран ажиллана.</p> |   |
| <p>ЗАСАГ ДАРГА</p>  |  <p>Ш Ө Л</p>       |
| <p>2126069715</p>   |   |

**АУДИТЫН ШИЙДЭЛ.**

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас тайлангийн төсөлд ирүүлсэн хариу тайлбарт дурдагдсан дээрх асуудлууд нь тайланд дурдагдаж байгаа бөгөөд Санхүүгийн тайлангийн аудитаар 85.4 сая төгрөгийн 2 албан шаардлага, 7 зөвлөмж өгсөн тул үүнтэй холбоотой аудитын шийдвэр гараагүй болно.

## ДҮГНЭЛТ

Дорнод аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Дорнод аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн ИТХ-аас үнэлж, дүгнээгүй байна.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилт 94.6 хувьтай байна.
3. Аймгийн татварын нийт орлого 13.5 хувиар буюу 9,192.2 сая төгрөгөөр давж биелсэн ч зарим нэр төрлийн орлого 1,743.2 сая төгрөгөөр тасарсан байна.
4. Хандив тусламжийн орлого 32.8 хувь буюу 1,675.0 сая төгрөгөөр тасарсан.
5. Аймагт төвлөрүүлэх орлогыг Хэрлэн сум 900.0 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.
6. Ерөнхий чиглэлийн судалгааг орон нутгийн 35 байгууллага, орон нутгийн өмчит 24 байгууллагыг хамруулан авахад УИХ-ын 2025 оны 48 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
7. Өмнөх аудитын шийдвэрийн биелэлт 88.7 хувийн хэрэгжилттэй байна.

Аудитаар нийт 5,866.6 сая төгрөгийн зөрчилд илэрсэнд 900.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,675.0 сая төгрөгийн 4 зөвлөмжийг хүргүүлэв.

## ЗӨВЛӨМЖ

### АЙМГИЙН ИТХ-д

1. Дорнод аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг үнэлж дүгнэх.

### АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА-д

1. Төсөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллах.
2. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дахь заалтын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний биелэлтийг хангуулан ажиллах.
3. Татварын орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд нийцүүлэн төлөвлөж байх.
4. Төрийн аудитын байгууллагаар хянагдаагүй төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгахгүй байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/13

Чойбалсан хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 2025 оны А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай
3. Аудитын тайланг Дорнод аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газарт хүргүүлэхийг аудитын менежер (Д.Нармандах)-д даалгасугай.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Г.Цолмон), Засаг дарга (Ш.Ёл)-д зөвлөсүгэй.
5. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Ө.Сийлэгмаа)-д үүрэг болгосугай.



Байгууллагын нэр: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар  
Газар хэлтэс: Захиргаа  
Албан тушаал: Дарга, Тэргүүлэх аудитор  
Овог нэр: Баярмагнай Болортуул  
Зурсан огноо: 2026.04.27 18:36:09

2125020048

ДОРНОД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Дарга, Тэргүүлэх аудиторын 2026 оны  
04 дүгээр сарын 27-өдрийн 1/2 дүгээр  
тушаалын хавсралт

Төлбөрийн актын жагсаалт

| № | Байгууллагын нэр, албан тушаал | Аудитын код              | Төлбөрийн актын утга  | Мөнгөн дүн сая/төгрөг |
|---|--------------------------------|--------------------------|---|-----------------------|
| 1 | Хэрлэн сумын Засаг дарга       | ДОА-2026/02-9/СТА-НА-НТГ | Хэрлэн сум нь аймагт төвлөрүүлэх орлогыг 900.0 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн | 900.0                 |
|   | <b>ДҮН</b>                     |                          |   | <b>900.0</b>          |

Албан шаардлагын жагсаалт

| № | Байгууллагын нэр, албан тушаал | Аудитын код              | Албан шаардлагын утга   | Мөнгөн дүн сая/төгрөг |
|---|--------------------------------|--------------------------|---|-----------------------|
| 1 | Аймгийн Засаг дарга            | ДОА-2026/02-9/СТА-НА-НТГ | ТАБ-аас 2025 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтээр хянагдаагүй 11 төсөл, арга хэмжээг нэмж, 10 арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэн баталсан | 3,291.6               |
|   | <b>ДҮН</b>                     |                          |   | <b>3,291.6</b>        |

